



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2014 оны 12 дугаар сар

Гадаад худалдааны эргэлт: \$11,011.2 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 11,011.2 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.6%-иар буюу 384.3 сая ам.доллараар өссөн. Үүнд импорт 1,121.2 сая ам.доллараар буурсан ч экспорт 1,505.5 сая ам.доллараар өссөн нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 61.8% буюу 6,799.9 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 14.6% буюу 1,610.9 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 23.9%-иар өссөн бол ОХУ-тай хийсэн худалдаа 0.8%-иар буурчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: \$537.9 сая

Мөнгөн дүн 2014 оны эхний 12 сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 2,626.7 сая ам.доллараар буурснаар 537.9 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь экспорт 35.3%-иар өссөн, импорт 17.6%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан бол 2014 оны эхнээс өсөх хандлага руу орсон. Энэ нь оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсантай холбоотой байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$857.8 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны эхний 12 сарын гүйцэтгэлээр 857.8 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 2,510.8 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй экспорт 34.1%-иар өссөн, импорт 17.9%-иар буурсан нь нөлөөлсөн.

Гадаад худалдааны нөхцөл: 1.588 (Туршилт тооцоо)


Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2012 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.588-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.9%-иар өсч, өмнөх сараас 0.3%-иар буурлаа.

Гадаад худалдааны нөхцөл ийнхүү өөрчлөгдөхөд экспортын үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7%-иар өсч, импортын үнийн индекс 5.7%-иар буурсан нь нөлөөлсөн байна. Экспортын үнийн өсөлтэд зэсийн баяжмалын үнийн өсөлт голлон нөлөөлсөн бол импортын үнийн бууралтанд машин, тоног төхөөрөмж, барилгын материал, нефтийн бүтээгдэхүүний үнэ буурсан зэрэг нь нөлөөлжээ.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхийн 12 сар			Өөрчлөлт			
	2014	2013	2012	2014/2013		2013/2012	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	11,011.2	10,626.9	11,123.0	384.3	3.6%	(496.2)	-4.5%
Экспорт	5,774.6	4,269.1	4,384.7	1,505.5	35.3%	(115.6)	-2.6%
Импорт	5,236.6	6,357.8	6,738.4	(1,121.2)	-17.6%	(380.6)	-5.6%
Тэнцэл	537.9	(2,088.8)	(2,353.7)	2,626.7	-125.8%	264.9	-11.3%


Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



Бүтэц: 89% + 11%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өсч нийт экспортын 89%-ийг бурдуулэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 88%, нийт экспортын 78%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 2.1 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 2.2 нэгж хувиар тус тус өссөн байна.

Өсөлт: +35.3%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 35.3%-иар өссөн бөгөөд уг өсөлтийн 31.7%-ийг ашигт малтмалын экспортын өсөлт бүрдүүлсэн байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал, боловсруулаагүй нефть болон мөнгөжүүлээгүй алтны экспортын өсөлт нь уг бүлгийн өсөлтийн 49%-ийг бүрдүүлжээ. Харин чулуун нүүрс болон тэмрийн хүдрийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 24%, 32%-иар буурсан нь уг бүлгийн өсөлтийг 13%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүн тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 1,401.4 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 104.1 сая ам.доллараар тус тус өссөнөөр нийтдээ 1,505.5 сая ам.доллараар өссөн байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ өссөнхөөс шалтгаалж 1,225 сая ам.доллараар өсөх нөлөө үзүүлсэн бол төмрийн хүдэр, цайрын экспортын тоо хэмжээ буурснаас, мөн чулун нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 583 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний үнэ, бусад экспортын бүтээгдэхүүний үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс харгалзан 40.8 болон 112.4 сая ам.доллараар экспорт өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар унц тутамд 1,184.4-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 1.4%-иар буурч, өмнөх сараас 1.5%-иар өссөн байна.

А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 6,368.0, 69.0 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 0.7%-иар, төмрийн хүдэр 1.4%-иар, өмнөх жилийн мөн үеэс зэс 13.7%-иар, төмрийн хүдэр 48.6%-иар тус тус буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2014			2013			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн.к)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн.к)	Дүн	%	Дүн	%	% 2
1. Ашигт малтмал	5,129	89%		3,777	88%		1,352	36%	31.7%
Чулуун нүүрс	19,481	849	15%	18,194	1,116	26%	(268)	-24%	-7%
Зэсийн баяжмал	1,378	2,574	45%	650	949	22%	1,625	↑171%	43%
Төмрийн худэрбаяж.	6,324	446	8%	6,724	654	15%	(208)	-32%	-6%
Боловсруулагуй нефть	6,885	635	11%	5,244	515	12%	119	23%	3%
Цайрын худэр ба баяж.	99	113	2%	131	119	3%	(6)	-5%	0%
Мөнгөжөөгүй алт	10,041	405	7%	7,559	310	7%	95	31%	3%
Жонш, лейцит, нефелин	314	72	1%	338	83	2%	(12)	-14%	0%
Молибденийн худэрбаяж	4	36	1%	4	29	1%	6	21%	0%
2. Ноос, ноолуур	285.7	5%		244.9	6%		41	17%	1%
Ямааны угаа ноолуур	4,035	224	4%	4,070	189	4%	35.0	19%	14%
Ямааны сам.ноолуур	637	62	1%	564	56	1%	5.9	10%	2%
3. Бусад	360	6%		248	6%		112	45%	3%
Нийт дун		5,775			4,269		1,505.5	▲35.3%	

% 2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны зорилж (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Ашигт малтмал	1,392		20		1352	
Чулуун нүүрс	79	30%	(347)	-130%	(268)	-24%
Зэсийн баяжмал	1,064	65%	561	35%	1,625	17.1%
Темрийн худар ба баяжмал	(39)	-19%	(169)	-81%	(208)	-32%
Боловсрууллагын нефть	161	135%	(42)	-35%	119	23%
Цайрын худар ба баяжмал	(29)	-484%	23	384%	(6)	-5%
Мянгажавгуялт	102	107%	(6)	-7%	95	31%
Жонш, лейцит, нефелинт	(6)	-5%	(6)	-49%	(12)	-14%
Молибдений худар ба баяжмал	0	6%	6	94%	6	21%
2. Ноос, ноолуур	5.6		35.3		40.8	
Ямааны угассан ноолуур	(16)	-5%	36.6	105%	35.0	19%
Ямааны самнасан ноолуур	7.2	122%	(13)	-22%	5.9	10%
3. Бусад	63	56%	49	44%	112.4	45%
Нийт	1,401.4		104.1		1,505.5	

Лурслэг 5. Лэлхийн зах зээп дээрх арт шайр зэсийн унийн динамик



Бүтэц: 26% + 40% +22%

Эхний 12 сарын байдлаар нийт импортын 26%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 40%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 22%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бурдуулж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний нийт импортоод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4%-иар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний хувийн жин өнгөрсөн оны мөн үеийн түвшинд хадгалагдсан байна.

Өсөлт: -17.6%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт нь 11%-ийг, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт 4%-ийг тус тус тайлбарлаж байна. Эхний 3 сарын байдлаар нефтийн импорт нийт импортын бууралтын 8%-ийг тайлбарлаж байсан бол 2 дугаар улирлаас эхлэн нефтийн импорт өссөнөөр уг үзүүлэлт 4% болж буурсан байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх онос 26%-иар буюу 726 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 18%-иар буюу 255 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 17.6%-иар буюу 1,121 сая ам.доллараар буурахад голлон нөлөөлжээ.

Задаргаа

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 10%-иар буюу 147 сая ам.доллараар буурахад удаан эдэлгээтэй барааны импорт, ялангуяа суудлын автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 26%-иар буурсан нь голлон нөлөөлжээ. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эзэст сөрөг тэмдэгтэй 11%-д хүрсэн /Дүрслэл 7/. Оны эхний хагаст хэрэглээний барааны импортын өсөлт тогтмол байсан бол 6 сараас эхлэн буурч, харин сүүлийн саруудад бууралтын хурд баагассан байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 38%-иар буюу 697 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Харин барилгын материалын импорт өнгөрсөн оны түвшинд хадгалагдсан байна.

Аж үйлдвэрлэлийн орцын импорт 1%-иар буюу 4 сая ам.доллараар буурч, өнгөрсөн оны түвшинд хадгалагдсан байна. Оюутолгойн зэс, алтны уурхайн үйл ажиллагаа жигдэрснээр 2013 оны 5 сараас эхлэн эрчим хүчиний импорт нэмэгдсэн.

Нефтийн бүтээгдэхүүний импорт 18%-иар буюу 255 сая ам.доллараар буурчээ. Дүрслэл 8-с үзэхэд хилийн үнэ 2012 оны сүүлээс эхлэн буурч, 2013 оны 9 сараас өсөх хандлагатай болсон. Гэвч 2013 оны төгсгөлөөс эхлэн дахин буурсан ба 2014 оны 12 сарын байдлаар 2010 оноос хойши хамгийн доод түвшиндээ хүрсэн байна.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2014		2013		Өөрчлөлт		
	Дүн	%	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2*
Хэрэглээний бүтээгдэхүүн	1,379	26%	1,526	24%	(147)	-10%	-2%
Түргэн эзлэгээтай	764	15%	780	12%	(17)	-2%	-1%
Хүнс	531	10%	559	9%	(27)	-5%	-2%
Эм, тарца	82	2%	77	1%	5	6%	0%
Бусад түргэн эзлэгээтай бараа	151	3%	145	2%	6	4%	0%
Удаан эзлэгээтай	615	12%	745	12%	(130)	-17%	-9%
Гутал, хувцас, цунх	58	1%	55	1%	3	5%	0%
Гэр ахуйн цах.хэрэгслэл ба тавилга	137	3%	156	2%	(19)	-12%	-1%
Авто машин, түүчин салбэг хэрэгслэл	348	7%	462	7%	(114)	-25%	-7%
Бусад удаан эзлэгээтай бараа	73	1%	72	1%	1	1%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	2,098	40%	2,824	44%	(726)	-26%	-11%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	1,114	21%	1,810	28%	(697)	-38%	-25%
Судлаас бусад тээврийн хэрэгслэл, эд анхи	281	5%	559	9%	(278)	-50%	-10%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	832	16%	1,251	20%	(419)	-33%	-15%
Барилгын материал	756	14%	748	12%	8	1%	0%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	228	4%	266	4%	(38)	-14%	-1%
Аж үйлдвэрлэлийн орц	592	11%	595	9%	(4)	-1%	0%
Хүнсний орц	32	1%	19	0%	13	67%	2%
Химийн бүтээгдэхүүн	93	2%	97	2%	(4)	-4%	-1%
Даавуу, утас, арьс, савхин эзлэл	17	0%	25	0%	(8)	-33%	-1%
Цахилгамж эрээм хүч	130	2%	113	2%	17	15%	3%
Металлын худар, баяжгал болон хаягдал	0	0%	1	0%	(1)	-51%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалт	319.68	6%	341	5%	(21)	-6%	-4%
Нефтийн бүтээгдэхүүн	1,155	22%	1,409	22%	(255)	-18%	-4%
Дизель тунш	656	13%	881	14%	(224)	-25%	-16%
АИ-92, АИ-95	320	6%	325	5%	(5)	-2%	0%
А-80 болон бусад	178	3%	203	3%	(25)	-12%	-2%
Бусад	14	0%	3	0%	10	315%	0%
Нийт дүн	5,237		6,358		(1,121)	-17.6%	

%2 - Ерөнхий булагийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (*contribution to the growth*)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дурслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

